



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2025/002/НА-СТА-ЗГТС**

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10-11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11-13
4. Аудитын тайлан	12-14
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14-15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	15-16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	17

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Л.ЗОРИГТБААТАР ТАНАА

2025.02.24 № СЭА-2025/002/НА-СТА-3ГТЦ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд 8 хөтөлбөрт 1,421,495.2 мянган төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр 1,285,775.6 мянган төгрөг зарцуулж, 135,719.6 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь 2 удаа хуралдсан боловч ХЭҮЗ-ийн 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн дүрэм”-ийн 2.2.3-т “... хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих” гэж заасан үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэгийг төлүүлэх талаар үр нөлөө бүхий шийдвэр гаргаагүй байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд тус сангаас санхүүгийн дэмжлэг олгоход шаардлагатай баримт бичгийн бүрдэлд батлан даалтын гэрээнээс гадна “Монгол банкны мэдээллийн сангийн лавлагаа”-г нэмэлт материалаар авсан нь санхүүгийн дэмжлэгийг графикт хугацаанд эргэн төлүүлэх хөшүүрэг болсон байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>1,387,731,500.00</b>	<b>1,527,058.285.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,387,731,500.00</b>	<b>1,527,058.285.00</b>
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	1,274,686,850.00	<b>1,527,058.285.00</b>
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	737,546,460.00	725,031,935.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	119,888,600.00	138,678,100.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	186,807,690.00	375,155,950.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	182,560,000.00	265,840,300.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	42,054,100.00	20,970,000.00
33730	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	5,830,000.00	1,382,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	113,044,650.00	0.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>1,387,731,500.00</b>	<b>1,527,058.285.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>1,387,731,500.00</b>	<b>1,527,058.285.00</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,387,731,500.00</b>	<b>1,527,058.285.00</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	1,387,731,500.00	<b>1,527,058.285.00</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,057,707,370.00	1,387,731,500.00
51220	Тайлант үеийн үр дүн	330,024,130.00	139,326,785.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>1,387,731,500.00</b>	<b>1,527,058.285.00</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,361,328,464.00</b>	<b>1,604,834,200.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,361,328,464.00</b>	<b>1,604,834,200.00</b>
1200	<b>Өмчийн орлого</b>	<b>1,361,328,464.00</b>	<b>1,604,834,200.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,361,328,464.00</b>	<b>1,604,834,200.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	278,333,000.00	223,923,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	335,304,464.00	183,339,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	747,691,000.00	1,197,572,200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>1,031,304,334.00</b>	<b>1,465,507,415.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,031,304,334.00</b>	<b>1,465,507,415.00</b>
210	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>43,589,200.00</b>	<b>45,864,550.00</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,589,200.00	45,864,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,589,200.00	45,864,550.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>987,715,134.00</b>	<b>1,419,642,865.00</b>
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>125,451,464.00</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	125,451,464.00	0.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>503,248,520.00</b>	<b>1,168,731,815.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	503,248,520.00	1,168,731,815.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>359,015,150.00</b>	<b>250,911,050.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	359,015,150.00	250,911,050.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>330,024,130.00</b>	<b>139,326,785.00</b>
6	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>330,024,130.00</b>	<b>139,326,785.00</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,361,328,464.00</b>	<b>1,717,878,850.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,361,328,464.00</b>	<b>1,717,878,850.00</b>
1200	<b>Өмчийн орлого</b>	<b>1,361,328,464.00</b>	<b>1,717,878,850.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,361,328,464.00</b>	<b>1,717,878,850.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	278,333,000.00	223,923,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	335,304,464.00	183,339,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	747,691,000.00	1,310,616,850.00
14	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>507,020,520.00</b>	<b>736,628,565.00</b>
145	Бусад орлого (олз)	507,020,520.00	736,628,565.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1,868,348,984.00</b>	<b>2,454,507,415.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,868,348,984.00</b>	<b>2,454,507,415.00</b>
210	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>43,589,200.00</b>	<b>45,864,550.00</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,589,200.00	45,864,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,589,200.00	45,864,550.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,824,759,784.00</b>	<b>2,408,642,865.00</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	113,044,650.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	113,044,650.00	0.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>125,451,464.00</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	125,451,464.00	0.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>503,248,520.00</b>	<b>1,168,731,815.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	503,248,520.00	1,168,731,815.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,083,015,150.00</b>	<b>1,239,911,050.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,083,015,150.00	1,239,911,050.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>(507,020,520.00)</b>	<b>(736,628,565.00)</b>
9	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>507,020,520.00</b>	<b>736,628,565.00</b>
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	507,020,520.00	736,628,565.00
10	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>	<b>507,020,520.00</b>	<b>507,020,520.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Дүн
1	2023 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
6	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	1,387,731,500.00	-	1,387,731,500.00
7	2024 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	-	1,387,731,500.00	-	1,387,731,500.00
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,387,731,500.00	-	1,387,731,500.00
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
11	Тайлант үеийн үр дүн	-	139,326,785.00	-	139,326,785.00
12	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	1,527,058,285.00	-	1,527,058,285.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,421,495,200</b>	<b>1,285,775,600</b>	<b>135,719,600</b>	<b>90.45</b>
120	НИЙТЛЭГ ТАТВАРЫН БУС ОРЛОГО			-	
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого			-	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,421,495,200</b>	<b>1,285,775,600</b>	<b>135,719,600</b>	<b>90.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,421,495,200</b>	<b>1,285,775,600</b>	<b>135,719,600</b>	<b>90.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>59,200,000</b>	<b>45,864,550</b>	<b>13,335,450</b>	<b>77.47</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,200,000	45,864,550	13,335,450	77.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,200,000	45,864,550	13,335,450	77.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,362,295,200</b>	<b>1,239,911,050</b>	<b>122,384,150</b>	<b>91.01</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,362,295,200	1,239,911,050	122,384,150	91.01
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,362,295,200	1,239,911,050	122,384,150	91.01
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,421,495,200</b>	<b>1,285,775,600</b>	<b>135,719,600</b>	<b>90.45</b>
32	ЗГ-ын гадаадын төслийн зээл	223,923,000	180,716,000	43,207,000	80.70
321102	Үндсэн төлбөр (ЗГ-ын дотоод зээл)	223,923,000	180,716,000	43,207,000	80.70
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,197,572,200</b>	<b>1,105,059,600</b>	<b>92,512,600</b>	<b>92.27</b>
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,197,572,200	1,105,059,600	92,512,600	92.27

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчилгээний нэр, төрөл, хүртээмжийг зорилтот бүлэг, хүн амд оновчтой хүргэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ажилгүйдлийг бууруулах, монгол хүний амьдралын чанарыг сайжруулах” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд “Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар халамжаас-хөдөлмөрт шилжих нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх” гэсэн зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- ХНХ-ын сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дүгээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээ”-г баталсан,
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)” -г шинэчлэн баталсан гэх мэт.

Тайлант онд ХХҮЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газраас тус сангийн санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн бөгөөд эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн болон хуваарийн дагуу төлөлт хийгээгүй зөрчилтэй иргэдэд мэдэгдэл хүргүүлэх, хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах зэрэг зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139,326.8 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Татаас санхүүжилтийн авлага	113,044.6	-	(113,044.6)
Хөтөлбөртэй холбоотой авлага	1,274,686.9	1,527,058.3	252,371.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,387,731.5</b>	<b>1,527,058.3</b>	<b>139,326.8</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,387,731.5	1,527,058.3	139,326.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,387,731.5</b>	<b>1,527,058.3</b>	<b>139,326.8</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Тайлант онд татаас санхүүжилтийн 113,044.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан,
- Хөтөлбөртэй холбоотой авлага дансны үлдэгдэл 1,527,058.3 мянган төгрөг болж 252,371.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт 989,000.0 мянган төгрөгийг олгож, эргэн төлөлтөөр 736,628.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь нэмэлт санхүүжилтийн дансгүй болно.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2024 оны төсвийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 70,000.0 мянган төгрөгөөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг 1,399,503.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналын нийт эх үүсвэрийг Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлсон 1 төсөл, хөтөлбөрийг 208,960.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 7 төсөл хөтөлбөрийг 741,891.4 мянган төгрөгөөр бууруулан 936,572.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 05 дугаар сард хийсэн төсвийн зохицуулалтаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох санхүүжилтийг 261,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,197,572.2 мянган төгрөг болгосон бол 11 дүгээр сард 223,923.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **1,421,495.2** мянган төгрөг болгон эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг 46,200.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 183,339.0 мянган төгрөг төвлөрүүлэн улсын төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,421,495.2 мянган төгрөгийг улсын төсвөөс авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,285,775.6 мянган төгрөг буюу 90.5 хувьтай байгаа нь нийт зардлыг 135,719.6 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	4,500.0	1,980.0	2,520.0	44.0
2	ХБИ-ийн ажлын байрыг дэмжих	189,923.0	180,716.0	9,207.0	95.2
3	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	38,960.0	6,502.0	32,458.0	16.7
4	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	26,425.5	21,280.7	5,144.8	80.5
5	Хөдөлмөрт бэлтгэх сургалт	49,170.0	30,406.3	18,763.7	61.8
6	Аж ахуй эрхлэлтийг дэмжих	962,416.7	935,910.0	26,506.7	97.2
7	Түр ажлын байрыг дэмжих	95,400.0	65,096.0	30,304.0	68.2

8	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	54,700.0	43,884.5	10,815.4	80.2
	<b>Дүн</b>	<b>1,421,495.2</b>	<b>1,285,775.6</b>	<b>135,719.6</b>	<b>90.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тайлант онд тус сангаас олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх графикт хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэгийг төлүүлэх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,031,304.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,313.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор сангийн үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулж, батлагдсан төсвийн хүрээнд ажиллан өр төлбөргүй тайлагнагдсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сангийн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, тайланд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт гэсэн 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус сангийн 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэгийн авлагыг барагдуулахтай холбоотой 1 зөвлөмж өгөгдсөнөөс хэрэгжилт 67.5 хувьтай байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хугацаа хэтэрсэн 47 иргэний 83,361.8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн төлүүлж, хэрэгжилт 67.5 хувьтай тайлагнагдсан бол 12 иргэний 30,698.8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг төлүүлэхтэй холбоотой шүүхийн шийдвэр гаргуулан, шийдвэр гүйцэтгүүлэх арга хэмжээг авч ажилласан байна.

Хүснэгт 4. Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	123,410.6	1	83,361.8	67.5
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>123,410.6</b>	<b>1</b>	<b>83,361.8</b>	<b>67.5</b>

Өмнөх онд өгөгдсөн төсөл хөтөлбөрийн эргэн төлөгдөх графикт хугацаа дууссан авлагыг барагдуулаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй буюу 2 иргэний 9,350.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам” -ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас санхүүгийн дэмжлэгийн шалгарсан төсөл, дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг газар дээр нь шалгах боломжгүй байсан учир дараагийн аудитаар тулган баталгаажуулах нь зүйтэй юм.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 22,804.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 9,350.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 13,454.0 мянган төгрөгийн зөрчилд<sup>1</sup> зөвлөмж өгөв.

#### 5.1 Албан шаардлага

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр 2017, 2019 онд малчдын болон залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс олгосон 2

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

иргэний 9,350.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн дэмжлэгийг барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...”, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга болон санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэний хооронд 2017, 2019 онд байгуулсан “Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээ”-ний 2 дугаар зүйлийн 2.3, 2.7, 3 дугаар зүйлийн 3.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам” -ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **5.2 Зөвлөмж**

### **1. Авлагын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 8 иргэнд олгосон 13,454.0 мянган төгрөг / “Аж, ахуй эрхлэгч иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 3 иргэний 3,423.0 мянган төгрөг, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 3 иргэний 7,310.0 мянган төгрөг, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2 иргэний 2,721.0 мянган төгрөг ) -ийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх графикт хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...”, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга болон санхүүгийн хөтөлбөрт хамрагдагч иргэний хооронд 2024 онд байгуулсан “Эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох гэрээ”-ний 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд олгосон санхүүгийн дэмжлэгийн авлагыг эргэн төлөлт хийх хуваарийн дагуу бүрэн барагдуулах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй	1	9,350.0			1	9,350.0						
Тайлант онд эргэн төлөгдөх графикт хугацаа хэтэрсэн санхүүгийн дэмжлэгийн авлагыг барагдуулаагүй	1	13,454.0					1	13,454.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>22,804.5</b>	-	-	<b>1</b>	<b>9,350.0</b>	<b>1</b>	<b>13,454.0</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 2 мэдээллийг мэдээлээгүй.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>